# НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН ХЭЛТСИЙН ДЭМЖИХ СИСТЕМ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Б.ОТГОНБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний бодлого, журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулна" (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 8)-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт өгөх | Санал, дүгнэлт зөвлөмжийн тоо | 6 | 4 | 1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлагын нэгдсэн систем"-д зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлтийг судалж, хариу тайлбарыг боловсруулан албан бичиг (2024.03.11, 03/489)-ээр хүргүүлсэн.<br>2. Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн "Хилийн байгууллагуудын хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем"-д зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт (2024.03.29, 03/646)-ийн дагуу "Гадаад иргэдийн мэдээллийн нэгдсэн систем (ГИМНС) ба хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоог дэмжих систем", "Хилийн боомт, хяналт бүртгэлийн систем (ХББХС)-ийг шинэчлэх болон хилийн удирдлагын нэгдсэн (ХУН) тогтолцоонд холбох өргөтгөлийн модуль", "Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем КАЙС (CEPS)-ийг хилийн удирдлагын нэгдсэн (ХУН) тогтолцоонд холбох өргөтгөлийн | 01 - 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | модуль”, “ОЛОН-ЧБ” хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд зориулсан хяналтын хэрэгслүүд бүхий ажлын даалгавруудад чиг үүргийн хүрээнд зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>3. “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ”-д зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт (2024.05.01, 01/196)-тэй танилцаж, чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>4. Соёлын яамнаас ирүүлсэн “Оюуны өмч ашиглалтыг бүртгэх, хэрэглээг хянах тоолуурын систем”, "Соёлын эрхий бичгийн систем"-ийн ажлын даалгаварт зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт (2024.04.30, 3/1162)-тэй танилцаж, чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>5. Онцгой байдлын ерөнхий газраас 2024 оны 2/1980 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Гамшгийн үеийн удирлагын нэгдсэн систем” хөгжүүлэх Ажлын даалгавартай танилцаж, чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>6. Зам, тээврийн яамнаас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03/1359 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем” хөгжүүлэх Ажлын даалгавартай танилцаж, чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн. | | |

| **Зорилт 2. “Шинжлэх ухааны байгууллага, судалгаа шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна” (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 10) -ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2.1.<br>Их өгөгдлийн (big data) сан үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 10.1) | Мэдээллийн сангийн тоо | 0 | 1 | Их өгөгдлийн сан үүсгэхэд шаардлагатай дараах бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Үүнд:<br>- Их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох судалгааг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэхээр ажлын даалгавар боловсруулан батлуулсан. Гүйцэтгэгчийн ирүүлсэн судалгааны тайлантай танилцаж, захиалагчийн шаардсан ажлын даалгаврын дагуу 2 удаа тулган шалгаж холбогдох засвар өөрчлөлт оруулах саналыг тусгаж, судалгааны тайланг хүлээн авсан.<br>- Ажлын хэсэг байгуулахаар ХЭҮК, ҮСХ, ТЕГ, И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-т хамтран ажиллах тухай албан бичиг /2024.10.23, 01/628/ боловсруулж, хүргүүлсэн.<br>- Хязгаарлалттай мэдээллийн хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах, их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаал (2024.11.15, А/51) батлуулсан. | 01-06 | 60 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэрэглэгч байгууллагын тоо | 0 | 2 | - Их өгөгдлийн санд мэдээлэл нийлүүлэх хэрэглэгч байгууллагаар Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ыг сонгон, нийгмийн халамж, нийгмийн даатгал, и-баримт, боловсролын төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг их өгөгдлийн санд нийлүүлэхэд хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлж ажилласан.<br>- Хүний хувийн мэдээлэлд хамаарах өгөгдлийг тодорхойлох боломжгүй болгох аргачлалын дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (И-Монголиа)-ээс үйлчилгээ авсан 10 мянган мөр өгөгдлийг сонгон анонимизаци болон псевдонизаци хийх аргуудыг ашиглан хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох туршилтыг И-Монгол академи УТҮГ-тай хамтран хийж гүйцэтгэсэн. | 06-12 | 40 |
| **Зорилт 3. “Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна”<br>(Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 11)** | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.1.<br>Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 11.2) | Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | 0 | 4 | - Ухаалаг засаг 2 төслөөр хэрэгжүүлэх “ХУР” мэдээлэл солилцооны системийг тархсан бүтэц шилжүүлэх системийн ажлын даалгавар боловсруулж, төсөл хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>- “ХУР” мэдээлэл солилцооны системийг тархсан бүтэц шилжүүлэх төсөлд техникийн зөвлөх сонгон шалгаруулах, үнэлэх ажлыг төсөл хариуцсан нэгж гүйцэтгэж байна | 03 - 12 | 30 |
| 4. | Арга хэмжээ 3.2. | Шилжүүлсэн системийн тоо | 0 | 50 | - Үндэсний дата төв УТҮГ нь 2024 оны IV улирлын байдлаар mCloud | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мэдээлэл хариуцагч байгууллагын системийг үүлэн (mCloud) системд шилжүүлэх (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 11.3) | | | | системд 54 байгууллагын үндсэн болон дэд систем бүхий нийт 292 зохиомол серверийг үүсгэж, ReHOSTING байдлаар үүлэн орчинд шилжүүлсэн.<br>- Мэдээлэл хариуцагч байгууллагаас шинээр үүсгэх системийг SaaS түвшинд нийцүүлэн хөгжүүлэлт хийхэд анхаарах талаар зөвлөмж, дүгнэлтэд тусгаж ажилласан.<br>- "Үндэсний дата төв" УТҮГ-ын үүлэн (mCloud) системд мэдээлэл хариуцагч байгууллагын системийг шилжүүлэх ажлын гүйцэтгэлийг сар тутам авч, хууль тогтоомжийн биелэлтэд тусгасан. | | |
| **Зорилт 4. "Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, нээлттэй өгөгдөл, мэдээллийг уялдуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна" (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 12)** | | | | | | | |
| 5. | Арга хэмжээ 4.1.<br>Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем нэвтрүүлэх | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | - "Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам батлах тухай" тогтоолын төслийг Засгийн газрын ээлжит хуралдаан (2024.02.28)-аар батлуулсан.<br>- Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлэхэд шаардлагататай ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан.<br>- "Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлэх" ЦХХХЯ/20240103036 дугаартай тендер шалгаруулалтыг Үнэлгээний хороо зохион байгуулсан хэдий ч оролцогчоос гомдол гарч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн | 01-06 | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол тухайн төсвийн жилд тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулахыг хориглоно.” гэсний дагуу уг тендерийг 2024 онд дахин зарлах боломжгүй болсон. | | |
| 6. | Арга хэмжээ 4.2.<br>Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 12.1) | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | 0 | 45 | - Мета-өгөгдлийн цахим платформ бий болгох ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран мэдээллийн сангийн мета-өгөгдөл цуглуулах цахим асуулгын хуудсыг боловсруулан, https://ee.kobotoolbox.org/x/NvY5ulj5 хэрэгслээр тоон болон чанарын судалгаа (тоон судалгаанд 43, чанарын судалгаанд 11 байгууллага) авсан.<br>- Мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сангийн мета-өгөгдлийн судалгаанд холбогдох мэдээллийг ирүүлээгүй, нөхөн ирүүлэх шаардлагатай мэдээлэл хариуцагч 15 байгууллагыг судалгаанд бүрэн хамруулах тухай албан бичиг (2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/402, 01/403, 01/404, 01/405, 01/407, 01/408, 409, 01/410 дугаар) боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.<br>- Үндэсний статистикийн хороотой хамтран судалгааны үр дүн бүхий мэдээллийн сангийн өгөгдлийг "Мета- | 06 - 12 | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгөгдлийн платформ"-ыг бий болгож, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. https://metadata.nso.mn/. Тус платформд төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийн багц (мэдээллийн сан) - 45, хүснэгт - 453, үзүүлэлт - 7137, ангилал, код - 725, тэдгээрийг цуглуулж буй маягт - 248 бүхий өгөгдлийг бүрдүүлээд байна. Ингэснээр суурь болон төрөлжсөн 45 мэдээллийн сангийн мета өгөгдлийг журамд заасан төрөлжсөн бүртгэлийн санд нэгтгэх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- “ҮНДЭСНИЙ ӨГӨГДЛИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ” арга хэмжээг Үндэсний статистикийн хороотой хамтран 2024 оны 05 сарын 24-ний өдөр зохион байгуулж, “Өгөгдлийн талаарх хууль, эрх зүйн орчин, дүрэм журам” сэдвээр илтгэл бэлтгэж, оролцсон.<br>- “Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлэх” ЦХХХЯ/20240103036 дугаартай тендер шалгаруулалт амжилтгүй болсноор цахимаар бүртгэл хөтлөх нөхцөл бүрдээгүй, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах боломжгүй болсон.<br>- Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн системүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлтийг Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор баталсан “Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт”-д багтсан 152 төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн шийдвэрлэж ажилласан. | | |

| Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн хүрээнд | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 1.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлах | Архивд хүлээлгэсэн өгсөн баримт бичгийн тоо | 0 | Хэрэгжил тээр | - Тайлант хугацаанд албан бичиг:<br>- Ирсэн бичиг - 47,<br>- Явуулсан /шийдвэрлэсэн/ - 39 | 01-12 | 100 |
| 8. | Арга хэмжээ 2.<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 0 | Хэрэгжил тээр | - Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв (11-11)-өөс ирүүлсэн иргэн М.Одбаярын гаргасан төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагаа (нийгмийн даатгал, архивын лавлагаа)-тай холбоотой хүсэлтийг судалж, хариу тайлбарыг бэлтгэн шийдвэрлэсэн.<br>- АЙ ЛО ИННОВЭЙТИВ ХХК-ийн ирүүлсэн дэмжлэг хүссэн хүсэлт бүхий Төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системийн “Иргэн” цэсэд байршуулсан “Хуулийн этгээд”-ийг улсын бүртгэлд бүртгүүлэх үйлчилгээ нь эрх зүйн ухаалаг үйлчилгээний www.iLaw.mn платформын эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглагдсан талаарх зөрчлийг шалган шийдвэрлэсэн хэргийн материал (112 хуудас)-тай танилцан, хариу тайлбарыг албан бичиг (2024-03-22, 02/575)-ээр хүргүүлсэн.<br>- 11-11 төвөөс ирүүлсэн Төрийн цахим үйлчилгээний системээс гаргах лавлагаа, тодорхойлолтыг ХААН банк хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай иргэн Ц.Сод-Одын саналыг судалж, холбогдох тайлбар, мэдээллийг өгсөн.<br>- Иргэн Я.Борхүүгийн ирүүлсэн ХААН банкнаас “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем”-ийн лавлагааг хүлээн | 01 - 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрөхгүй, иргэний үнэмлэх эх хувиар шаардсан талаарх хүсэлтийг судалж, хариу тайлбарыг бэлтгэн шийдвэрлэсэн. | | |
| 9. | Арга хэмжээ 3.<br>Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны удирдлагаар баталгаажуулах, үр дүнг хуульд заасан хугацаанд тайлагнах | Төлөвлөгөө, тайлан | 0 | Хэрэгжил тээр | - Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан.<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног, сар, I, II, III, IV, улирлаар тайлагнасан. | 01 -12 | 100 |
| 10. | Арга хэмжээ 4.<br>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) болон ХАСХУМ мэдүүлэх | Мэдүүлэг | - | Хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна | ХАСХОМ-ыг 2023.01.15-нд мэдүүлсэн. | 01 | 100 |
| 11. | Арга хэмжээ 5.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | Хэрэгжил тээр | Албан үүргийн дагуу шийдвэрийн төсөл боловсруулах, төрийн байгууллага болон хүн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөж ажилласан. | 01 -12 | 80 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлт, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлт, Монгол Улсын | Тайлан | 0 | 12 | - Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтэст хамаарах хууль тогтоомжийн биелэлтийг 1-12 сарын хугацаанд сар тутам гаргасан. | 01 - 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт | | | | - “Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлт, Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Алсын хараа-2050, Шинэ сэргэлт бодлого, Засгийн газрын 2020-2024 оны биелэлтийн эрчимжүүлэх шаардлагатай ажлын гүйцэтгэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн биелэлтийг тус тус гаргасан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ажлын хэсэг | Оролцсон ажлын хэсэг | 0 | Хэрэгжил тээр | - Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны Стратеги, төлөвлөгөө боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсгийн хүрээнд нийтийн мэдээллийн дэд бүтэц, цахим засаглал, инноваци, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах" үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.16-дахь заалтыг өөрчлөхтэй холбоотой санал боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Шүүн таслах үйл ажиллагаанд нээлттэй ил тод байдлыг сайжруулах болон төрийн цахим шилжилттэй уялдуулан шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг (Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 сарын 05-ны өдрийн А/97 тушаал)-ийн бүрэлдэхүүнд орж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах талаар санал, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд үндэслэл, практик шаардлагын талаарх мэдээллийг тус тус боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 04 сарын 12-ны өдрийн А/39 дугаар тушаал байгуулагдсан Ажлын хэсгийн удирдамжийн дагуу "Үндэсний дата төв" УТҮГ-ын үйл ажиллагаанд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох хууль тогтоомж, салбарт хэрэгжиж буй хууль эрх зүйн баримт бичиг, бодлогын хэрэгжилт, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний найдвартай ажиллагаа, яамнаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврын биелэлт зэрэг чиглэлээр хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 4 сарын 15-ны өдрийн №19 дүгээр тогтоолоор байгуулагдсан "Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах программ хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох" үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогчдын бүртгэлийн программ хангамжийн эх кодыг шалган баталгаажуулж, гэрчилгээ олгох, сонгогчдын ирц бүртгэлийг нэгтгэх, дүнг дэлгэцээр харуулах программ хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хянан шалгах ажлыг төлөвлөгөөнд заасан хуагцаа (2024. 06.03-2024.07.10)-нд хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдах нийт 2,780 зөөврийн компьютер, 1 серверийг тус тус баталгаажуулах;<br>- 13 тойргийн 2,198 хэсгийн хороонд ашиглах үндсэн болон нөөц 2,943 санал тоолох төхөөрөмжийг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох;<br>- Санал хураалтын өдөр 2,196 хэсгийн хороонд хуваарилсан санал тоолох | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмж (2,789)-ийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд мэдээллийн технологийн багийн 141 гишүүн, мэдээллийн технологийн 2618 даамалтай хамтран зохион байгуулж, Ажлын хэсгийн гишүүд шуурхай удирдлагаар хангах ажилд тус тус оролцсон.<br>- Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5 –д заасан "ард нийтийн санал асуулга болон сонгуулийн санал өгөх өдрийн тов"-ыг мэдэгдэл хүргэх систем ашиглан цахим хэлбэрээр хүргэх гэж заасны дагуу "сонгогчдын нэрийн жагсаалтад багтсан өөрийн нэр, хаягийн мэдээллийг нягтлах тухай", "сонгуулийн санал авах өдрийн тов", "хяналтын тооллого хийх тухай", "саналын хуудасны тухай" зэрэг мэдэгдлүүдийг "Үндэсний цахим шуудан" болон Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) бүхий сувгуудаар 2024 оны 06 сарын 14, 20, 27-ны өдрүүдэд тус тус хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.<br>- Ажлын хэсэг Үндэсний дата төв УТҮГ болон И-Монгол академи УТҮГ-тай хамтран Үндэсний цахим шуудангаар нийт 1,407,977, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) – ээр 1,318,574 хэрэглэгчдэд тус тус мэдэгдэл хүргэж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Шийдвэрийн төсөлд санал өгөх | Саналын тоо | 0 | Хэрэгжил тээр | - Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос санал авахаар ирүүлсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй танилцан, хог хаягдлын эко төлбөрийн талаар судалж, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгах санал (2024.04.29, 01/915 дугаар албан бичиг) боловсруулан хүргүүлсэн.<br>- Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос зөвлөмжид санал авахаар ирүүлсэн “Хот, хөдөөгийн сэргэлт” ажлын хэсгийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 15 дугаар хуралдаанаар хэлэлцсэн асуудлын хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн хүн амын зохистой харьцааг бий болгоход чиглэсэн Монгол Улсын Засгийн газраас гаргасан бодлого, шийдвэрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх зөвлөмжид санал (2024.04.26, 02/880) боловсруулан хүргүүлсэн.<br>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн “Нийгмийн даатгалын нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах, хамгаалах журам”-ын төсөлд санал боловсруулж, хүргүүлсэн. | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын хороо байгуулах тухай” тушаалын төсөлтэй танилцан, санал боловсруулж, албан бичиг (2024.01.24, 01/159 дугаар)-ээр хүргүүлсэн.<br>- Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ирүүлсэн /2024.10.21, УИХ-08/4403/ Монгол Улсын 2025 оны төсвийн өргөн мэдүүлсэн төсөлд тусгагдсан, арга хэмжээнүүдэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан зөвлөмж, дүгнэлт гаргуулсан эсэх талаар хүсэлтэд хариу бичиг боловсруулж хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ны өдрийн хуралдаанд танилцуулах Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хариуцсан чиг үүргийн хүрээнд бэлтгэж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлээр төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрээр мэдээлэл солилцох эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүн хуулийн этгээдээс цахим шуудан болон цахим хэлбэрээр төрийн байгууллагад илгээсэн, хүлээн авсан хаалттайгаас | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - бусад мэдээлэл, баримт бичгийг албан ёсны хүчинтэйд тооцох, архивлах асуудлаар холбогдох журамд өөрчлөлт оруулах саналыг хамтран боловсруулах талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл өгсний дагуу ажлын хэсэгт орж, санал боловсруулж, төсөлд тусгаж ажилласан. | | |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалт, семинарын тоо | 0 | 2 | - Үндэсний статистикийн хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Статистикийн газар хамтран 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан "ҮНДЭСНИЙ ӨГӨГДЛИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ" арга хэмжээнд оролцсон.<br>- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газраас (UNDESA) Монгол Улсын "Үндэсний өгөгдлийн засаглалын тогтолцооны суурь судалгаа"-ны үр дүнг хэлэлцэх уулзалтад Монгол Улсын өгөгдлийн талаарх бодлого, зохицуулалт сэдвээр илтгэл бэлтгэж, оролцсон. | 01 - 12 | 80 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд хамрагдах | Сургалт, хурал | 0 | 2 | - Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10 вебинар сургалт"-д тогтмол хамрагдсан. | 01 - 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Үндэсний статистикийн хорооноос 2024 оны 03 сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдал” сэдэвт уулзалтад оролцсон.<br>- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан мод тарих үйл ажиллагаанд 2024 оны 05 дугаар 21-ний өдөр оролцсон.<br>- МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Зохиогчийн эрх ба цахим орчны хамгаалалт” сэдэвт хэлэлцүүлэгт 2024 оны 11 дугаар 12-ны өдөр оролцсон. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Дэмжих систем хариуцсан шинжээч — Баатар овогтой Отгонбаяр

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*